



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2015 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 01

Өлгий

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх,
хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай

Ховд аймгийн Булган сумын Баянгол багийн нутаг "Доод нарийн" гэдэг газар малын гоц халдварт шүлхий өвчний сэжиг илэрсэн. Шүлхий өвчний сэжиг илэрсэн малаас дээж авч лабораторийн шинжилгээгээр оруулахад цусанд хийсэн шинжилгээгээр малын гоц халдварт шүлхий өвчин болох нь тогтоогдож байна.

Иймд малын гоц халдварт шүлхий өвчний халдвар тархах эрсдэл өндөр байгаа тул түүнээс сэргийлэх, хамгаалах ажлыг тасралтгүй зохион байгуулахтай холбогдуулан дараах АЛБАН ДААЛГАВАР-ыг хүргүүлж байна.

Нэг: Булган сумын Засаг дарга Х.Шынарбек болон сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт

1. Малын гоц халдварт шүлхий өвчний талаарх мэдээллийг сум, багийн иргэдэд шуурхай хүргэх.
2. Булган сумын нутаг дэвсгэр дээр олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж явуулахыг хориглох.
3. Булган сумаас малын гаралтай түүхий мах, боловсруулаагүй нойтон арьсыг тээвэрлэхийг зогсоох.
4. Булган сумын нутагт байрлах "Индэрт", "Улаагчин ам" гэсэн 2 газарт 24 цагаар пост ажиллуулах.
5. Дэлүүн сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга, орон нутгийн Хөх сэрхийн тусгай хамгаалалттай газартай хамтран "Бүргэд" уулын аманд пост ажиллуулах.
6. Голомтонд үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийг томилгоожуулж гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд сургалт явуулж сургаж бэлтгэх.
7. Малын гоц халдварт шүлхий өвчний голомттой газар хяналт шалгалт хийж, өвчлөл гарч болзошгүй газар нутагт айл буулгахгүй байх бүх талын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх.
8. Малын гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэгтэй, үхсэн мал амьтны сэг зэмээр оролдохгүй байх, тааралдсан тохиолдолд яаралтай мэдээлж байх талаар иргэдийг сургах.
9. Шаардлагатай тохиолдолд ард иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах
10. Өвчний анхны шинж тэмдэг илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай мэдээлэх дадалд иргэдийг сургах.
11. Малын гоц халдварт шүлхий өвчний голомтоор тээврийн хэрэгсэл, мал, хүнийг зорчихгүй байлгах тал дээр хяналт тавьж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

12. Сум, багийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчний голомттой болон гарах эрсдэлтэй газар нутгийг зураглалд оруулж танилцуулга гаргаж орон нутгийн хэмжээнд мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулах.

13. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин гарах магадлал өндөртэй тохиолдолд гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, сум, багийн нутаг дэвсгэрт хорио цээр, хязгаарлалт тогтоох, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх арга хэмжээг зохион байгуулах, голомтонд ажиллах хүн, хүч техник хэрэгслийг татан оролцуулах бэлтгэлийг урьдчилан хангасан байх.

14. Малын гоц халдварт шүлхий өвчний тандалтыг зохион байгуулж, сэжиг илэрсэн тохиолдолд нөхцөл байдлыг цаг алдалгүй шуурхай мэдээлэх.

15. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын талаарх мэдээллийг аймгийн Онцгой байдлын хэлтсийн 7042101, 89005903 дугаарын утсанд өдөр бүр мэдээлж байх.

Хоёр: Аймгийн Эрүүл мэндийн газар /С.Айгүл/-т,
Хүнс, хөдөө аж ахуй газар /Ж.Онгар/-т тус тус ДААЛГАХ нь:

1. Ард иргэдэд мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг шуурхай зохион байгуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх.

2. Өвчин гарч болзошгүй нутаг дэвсгэр, айл өрхийг тогтоох, өвчтэй болоод сэжигтэй малыг тусгайлан салган тусгаарлах, үхсэн ба өвчтэй малаас шинжилгээний материал дээж авах бэлтгэл ажлыг хангасан байх.

3. Эрүүл мэндийн болон Хүнс, хөдөө аж ахуй газрын нэгж байгууллагуудын яаралтай дуудлагаар явах бие бүрэлдэхүүний эм тариа, хамгаалах хувцасны бэлэн байдлыг хангах.

4. Малын гоц халдварт шүлхий өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед хөл хорио тогтоох асуудлыг танилцуулах, өвчний оношийг яаралтай тогтоож, эмчлэх ажлыг зохион байгуулах.

5. Халдварын голомтонд эцсийн ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах

6. Мал, амьтны түүхий мах, боловсруулаагүй нойтон арьсыг тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл, зорчигчдод ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах

Гурав: Аймгийн Цагдаагийн газар /М.Батболд/-т,
Тээвэр, авто замын газар /К.Сейфуллин/-т тус тус ДААЛГАХ нь:

1. Толбо сумаас Өлгий сумын чиглэлийн постын үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөлгөөнт хяналт шалгалт ажиллуулах, хот, суурин газар орж ирж байгаа мал, амьтны мах, түүхий эд, арьсанд хяналт тавьж ажиллах.

Дөрөв: Аймгийн Мэргэжлийн хяналтын газар /О.Акилбай/-т ДААЛГАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх, хамгаалах ажлын хүрээнд халдварт өвчний эм, био бэлдмэлийн хангалт, вакцинжуулалт, өвчлөл бий болсон тохиолдолд хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын арга хэмжээ сахиулах үйл ажиллагааг хянах.

2. Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаварын биелэлт, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилт, зааврын биелэлтэнд хяналт тавих.

3. Халдварт өвчнөөр өвчилсөн мал, амьтныг устгах, халдваргүйжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих.

Тав. Аймгийн "Наз", "Дербес" "TV-4" телевиз, Үндэсний радио-д ДААЛГАХ нь.


Малын гоц халдварт шүлхий өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтын дагуу үнэ төлбөргүй сурталчлах ажлыг зохион байгуулахыг тус тус даалгасугай.

Зургаа: Аймгийн Онцгой байдлын хэлтэс /Ц.Баттулга/-т ДААЛГАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс сэргийлэх, хамгаалах талаар ард иргэдэд хандаж бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр анхааруулга, сэрэмжлүүлэг хүргэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

2. Энэхүү албан даалгаврын хэрэгжилт, биелэлт болон орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагуудын ажлын явцад хяналт тавьж, үр дүнг аймгийн Онцгой комисс, аймгийн удирдлагад мэдээлж ажиллахыг тус тус үүрэг болгож байна.

ДАРГА



Х.ДАРМЕН